

ЭХ ХУВЬ

Монгол улс
БОУАӨЯ-НЫ ХБОБҮГ

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРЭГ, БОГДХАН УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ
ГАЗРЫН ЗАЙСАНГИЙН АМАНД ХЭРЭГЖИХ “АЯЛАГЧ, ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ
БУСАД ХҮН ТҮР БУУДАЛЛАХ, ОТОГЛОХ, АЖИГЛАЛТ, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ
ХИЙХ ЗОРИУЛАЛТААР ЗОХИХ ЖУРМЫН ДАГУУ БАРЬСАН ОРОН БАЙРЫГ
АШИГЛАХ” ТӨСЛИЙН

2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч:

“Хүлэгт хаадын зам” ХХК

Регистрийн дугаар:

5997003

Улаанбаатар хот

2026

ГАРЧИГ

НЭГ.	ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
ХОЁР.	ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
ГУРАВ.	ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ
ДӨРӨВ.	2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ


Улаанбаатар хотын Хан-уул дүүрэг, Богдхан уулын дархан цаазат газрын Зайсангийн аманд хэрэгжих “Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	“Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах”
Төсөл хэрэгжүүлэгч:	“Хүлэгт хаадын зам” ХХК, улсын бүртгэлийн дугаар: 99011564090, регистрийн дугаар: 5997003
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 дугаар хороо, Ноблесс хотхон 68-301, Утас: 99119933
Төслийн байршил:	Улаанбаатар, Хан-уул, Богдхан уулын ДЦГ, Зайсангийн ам, Соёмбот уулын энгэрт хэрэгжинэ.

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг




Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбицол

№	X	Y	Өргөрөг	Уртраг
1	642596.031	5304967.775	47° 52' 55.906" N	106° 54' 26.234" E
2	642618.983	5305103.626	47° 53' 0.286" N	106° 54' 27.500" E
3	642649.870	5305103.970	47° 53' 0.272" N	106° 54' 28.987" E
4	642658.9594	5304965.972	47° 52' 55.798" N	106° 54' 29.260" E

1.2. Төслийн хүчин чадал

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн байгаль орчин, агаарын чанар, амьдрах орчны стандартыг харгалзан дэд бүтцийн зохистой шийдэлтэй аюулгүй орон сууцны хорооллыг байгуулах зорилготой. Уг төсөл нь хотын хүн амын суурьшлын бүсийг тэлэх, өндөр чанартай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэж байна. Нийт 8049.76 м^2 ашиглах талбайгаас 3219.9 м^2 нь бариллагжих талбай байна. Архитектур төлөвлөлтийн даалгаврын хязгаарт багтааж 9 давхар жуулчид түр отоглох 4 блок барилга төлөвлөж 1 блок нь давхартаа 7н өрөө байхаар нийт 252 өрөө түр отоглох сууц төлөвлөсөн.

Зураг 2. Төслийн төлөвлөлт



1.2.1. Үндсэн үзүүлэлт

- Нийт эдэлбэр газрын хэмжээ 8049.76 м^2
- Нийт барилгажих талбай 3219.9 м^2 ,
- Автозамын талбай 2276 м^2 ,
- Явган хүний зам 1174 м^2 ,
- Ил авто зогсоол 64ш,
- Далд авто зогсоол 3 давхар шаталсан 152ш,
- Буудаллах байр А, Б, В, Г блокоос бүрдэх тус бүр 9 давхар,
- Ногоон байгууламж 2011 м^2 , /Монос, Улиас, Гацуур, шар хуайс 3400 ш /
- Хүүхдийн тоглоомын талбай 221 м^2 ,

1.2.2. Ажиллах хүч

Төсөл хэрэгжүүлэх үед 100 хүнийг байнгын ажлын байраар хангана. Дээрх мэргэжлийн хүмүүс нь доорх үүрэг хариуцлагатайгаар ажил үүргээ гүйцэтгэнэ.

1.3. Уурхайн дэд бүтцийн байгууламж

1.3.1. Цахилгаан хангамж

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК –ийн 2025 оны 09 сарын 01 –ний Дугаар № 508/2025 техникийн нөхцөлийг 2027 оны 09 сарын 01 хүртэл гаргуулсан. Дулаан эрчим хүчний хэрэглээ 0.60 Гкал/цаг , мөн “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК –ийн 2025 оны 05 сарын 15 –ны өдрийн дугаар 01/01869/25 техникийн нөхцөлийг 700 кВА , 10 кВ байхаар батлуулсан байна.

1.3.2. Усан хангамж

УСУГ болон “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК –ийн 2025 оны 09 сарын 01 –ний Дугаар № 508/2025 техникийн нөхцөлийн дагуу ус хангамжийг төвлөрсөн шугамаас авч хэрэглэнэ. Аялал жуулчлалын цогцолборын ажилчдын усны хэрэглээний тооцооллыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа (*-БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт- Төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон орон сууц 200.0 л/хон) Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний нормын 14 дүгээр хавсралтад дээр үндэслэн тооцов. Төсөл нэг ээлждээ бүх хүчин чадлаараа ажиллахад 400 жуулчин хүлээн авах хүчин чадалтай.

Ажилчид болон амрагчдын унд ахуйн усны хэрэглээ

Хүснэгт 2. Төслийн унд ахуйн усны тооцоо

Усны хэрэглээний төрөл	Нэг хүний өдрийн норм	Төслийн хугацаа, хон/жил	Хүний тоо/Ажилчид/	Ус хэрэглээ	
				м³/хон	м³/жил
Унд-Ахуйн	200 л/хон	365	100	20	7300.0

Үйлчилгээний ус хэрэглээ

Үйлчилгээнд зарцуулагдах усыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2015 оны 07 дугаар 30-ны А/301 дугаар тушаалаар баталсан Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний нормын 14 дүгээр хавсралтын 24 дугаар заалтыг үндэслэж тооцов.

Хүснэгт 3. Төслийн үйлчилгээнд ашиглагдах усны тооцоо

Үйлчилгээний төрөл	Хүний Тоо /Амрагчид/	Хэмжих нэгж	Усны хэрэглээ литр	Ажиллах хугацаа	Нийт	
					м³/хоног	м³/жил
Аялал жуулчлалын цогцолбор	400	л/хон	200	365	80	29200

Ажилчид болон амрагчдын унд ахуйн усны тооцоогоор хоногт хэрэглэх нийт цэвэр усны хэрэглээ нь 100 м³/хоног байгаа нь Ус сувгийн удирдах газрын 2025 оны 09 сарын 16 –ны өдрийн № 662/25 техникийн нөхөлцийг хангаж байна.

Ногоон байгууламжийн усалгаа

Ногоон байгууламжийн усалгааг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 13 дугаар хавсралтын 6,7 дугаар заалтыг үндэслэн тооцов.

Хүснэгт 4. Ногоон байгууламжид ашиглагдах тооцоо

Усны хэрэглээний төрөл	Усалгаа жил/хоног	Норм	Ногоон байгууламжийн хэмжээ ширхэг	Ус хэрэглээ	
				м³/хон	м³/жил
Буг, сөөг	12 хон	40	3400 ш	136	1632
Цэцэрлэг зүлэг ногоо услах	14 хон	4 л	2011 м²	8	112

Уг төслийн ашиглалтын үед бүх хүчин чадлаараа ажиллах үед хоногт 244 м³ ашиглах бөгөөд жилд 38244 м³ ашиглахаар байна.

1.3.3. Харилцаа холбоо

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь үүрэн телефоны бүхий л сүлжээг ашиглах боломжтой бөгөөд үйл ажиллагаандаа дотоод сүлжээгээр барилгын автомат хяналтын систем, дохиолол хамгаалалтын системийг ашиглана.

1.4. Хог хаягдлын менежмент

Хог хаягдлын менежмент гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлын эх үүсвэрийг бууруулах, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах бүхий л процессыг хянаж сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ юм. Тус лабораторийн үйл ажиллагаанаас гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдал, химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг Хог хаягдлын тухай хууль /2017 он/- ийн дагуу байгууллагын хог хаягдлын менежментийн дотоод журмыг боловсруулж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхийн зэрэгцээ хог хаягдлыг газар дээр нь ангилан ялгах нөхцөл бололцоог хангаж ажиллах нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг юм. Хог хаягдлын төрөл, эх үүсвэрээс хамаарч хог хаягдлын менежмент тухай бүр харилцан адилгүй байдаг тул дараах хүснэгтэд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусган харуулав.

Хүснэгт 5. Лабораторид хийгдэх шинжилгээний төрөл

№	Хог хаягдлын төрөл	Эх үүсвэр	Хог хаягдлын менежментийн арга хэмжээ	Баримтлах эрх зүй, стандарт
1	Ахуйн хатуу хог хаягдал	Ажилчдын ахуйн хэрэглээ	“Хан-Уул Агро” ААТҮГ-тай хог хаягдалд цуглуулж нийлүүлнэ.	Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага
2	Ахуйн шингэн хог хаягдал	Ажилчдын ахуйн бохир ус	Төвийн бохирын шугам руу нийлүүлнэ.	Бохир ус зайлуулах төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх үйлдвэрийн бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээ

Ахуйн хатуу хог хаягдлын хэмжээ: Ахуйн хатуу хог хаягдлын хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 сарын 25-ны өдрийн А/368 дугаар тушаалын хавсралт “Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал”-ын Дөрөв. Аж ахуйн нэгж, байгууллага, салбарын хаягдлын нормативаар тооцоход нэг ажилтан өдөрт ажиллах хугацаандаа 1.5 кг хог хаягдал гаргадаг. Иймд 100 ажилтан өдөрт 150 кг, 400 жуулчин өдөрт 600 кг, нийт 750 кг хатуу хог хаягдал гаргахаар байна.

Ахуйн шингэн хог хаягдлын хэмжээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 14 дүгээр хавсралтад заасан жишиг нормын дагуу тооцов. Үүнд, нэг ажилтан хоногт дунджаар 40 литр цэвэр ус хэрэглэхээр тооцвол нийт 100 ажилтнаас хоногт 4,000 литр цэвэр ус зарцуулагдана. Мөн жуулчны баазад байрлан үйлчлүүлэх нэг жуулчин хоногт дунджаар 120 литр цэвэр ус хэрэглэх ба нийт 400 жуулчнаас хоногт 48,000 литр цэвэр ус хэрэглэгдэхээр байна.

Ингэснээр төслийн үйл ажиллагааны явцад хоногт нийт 52,000 литр цэвэр ус хэрэглэгдэх тооцоо гарч байна. MNS 4943:2015 “Бохир ус. Ангилал, чанарын үзүүлэлт” стандартын дагуу ахуйн хэрэглэсэн цэвэр усны ойролцоогоор 70 хувь нь бохир ус болж үүсдэг гэж үзвэл төслөөс хоногт 36,400 литр орчим ахуйн бохир ус үүсэхээр байна. Энэ нь Ус сувгийн удирдах газрын 2025 оны 09 сарын 16 –ны өдрийн № 662/25 техникийн нөхөлцийг хангаж байна.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн физик газарзүйн онцлог

Улаанбаатар хот, түүний орчмын нутаг дэвсгэр нь далайн түвшнээс дээш 1300-1350 м өргөгдсөн. Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хэнтийн их мужийн Хэнтийн баруун дэд мужид ойт хээрийн бүсэд үзүүрт Туул голын хөндийн 2.5-4 км хүртэл өргөссөн татам болон дэнж, Их Хэнтийн нурууны баруун өмнөд салбар уулс, түүний дэд мужийн ойт хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1950-2265 м үнэмлэхүй өндөртэй Горхи, Тэрэлж, Богд хан, Сонгино Хайрхан Чингэлтэй, Баянзүрх зэрэг биеэ даасан өндөрлөг уулс, тэдгээрийн салбар уулсаар Туул голын 1250-1345 м үнэмлэхүй өндөр бүхий тэвш маягийн хөндийн 2.5-4.0 км хүртэл өргөссөн татам, дээрх уулсын энгэр, бэл, хормой, дэнжид тархан, 470444 га талбай бүхий нутаг дэвсгэр эзлэн оршино.

Төслийн талбай нь Богдхан уулын баруун хойно Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд оршино. Газарзүйн нөхцөл, газрын гадрагын хувьд Богдхан уул зүүнээс баруун тийш чиглэсэн их нуруу болон түүний салбар уулсаас бүрдэнэ. Богдхан уулын хамгийн өндөр оргил нь далайн түвшнээс дээш 2268 метр өндөрт өргөгдсөн Цэцээ Гүн, 2256 метр өндөрт орших Түшээ гүн хэмээх оргилууд болно. Богдхан ууланд 2000 метрээс дээш өргөгдсөн эртний тэгшрэлийн гадарга голлоно. Тэгшрэлийн гадаргын үнэмлэхүй өндөр 1800, 2000, 2200 метрийн түвшинд гурван үндсэн шатлал үүсгэсэн байна.

2.2. Төсөл хэрэгжих газрын гадаргын налуу

Газрын гадаргын налуу нь суурьшлын бүс газрын барилга, байгууламж барьж байгуулахад ихээхэн нөлөөтэй болохыг зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барих талбайн бэлтгэл, газар шорооны ажилтай шууд холбож үздэг. Газрын гадаргын налуу ихсэх тутам газар шорооны ажлын хэмжээ мөн төдий чинээ нэмэгддэгтэй холбоотой. Иймд газрын гадаргын налуугийн олон төрөл байдал нь хот төлөвлөлтийн үүднээс эзлэхүүн, орон зайн төлөвлөлтөд өвөрмөц үүрэг гүйцэтгэх бөгөөд хот, суурингийн янз бүрийн үүрэг зориулалтын бүсүүдийг гадаргын налуугийн хүчин зүйл, тухайн суурингийн онцлог байдалтай уялдуулан төлөвлөж барьж байгуулах нь зүйтэй юм.

Улаанбаатар хот Туул, Сэлбэ, Улиастай зэрэг хойд мөсөн далайн ай савд хамаарах голууд тархсан бөгөөд голын хөндийг хүрээлсэн Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх, Толгойт, Баянхошуу, Баянцогт, Хойд Баян, Цагдуулт зэрэг уулсын үнэмлэхүй өндрийн хэмжээ 1515-1950м, тэдгээрээс хамгийн өндөр оргил болох Богдхан уулын үнэмлэхүй өндөр нь 2265 м хүрдэг. Улаанбаатар хотын эргэн тойрны бэсрэг уулс болох Толгойт, Баян хошуу, Баянцогт, Хойт Баян, Цагдуулт зэрэг уулсын үнэмлэхүй өндөр нь дунджаар 1513-1831 м байх ба хажуу налуугийн хэвгий нь 15-20 хэм, зарим хэсэгтээ 30-35 хэм хүрдэг.

2.3. Төслийн талбайн газрын гадаргын өндөржилт

Хот, суурингийн байрлаж буй газрын өндөржилт ихсэх тутам агаарын хүчилтөрөгчийн агуулга болон температур буурч, өдөр шөнийн температурын зөрүү огцом өсч, салхины хүч ширүүсэн, агаарын хуурайшил нэмэгдэн, цаг уурын бусад өөрчлөлтүүдээс шалтгаалж, оршин суугчдын ая тухтай байдал алдагдан, эрүүл мэндэд нөлөөлөхөөс гадна барилга байгууламжийн ашиглалтад сөрөг үр дүн үзүүлдэг байна. Эмнэлэг-биологийн шаардлагаас үндэслэн, хот байгуулалтын хувьд далайн түвшнээс дээш 1500 м хүртэл өндөржилттэй бол тохиромжтой, 1500-2500м хүртэл хязгаарлагдмал тохиромжтой, 2500 м-ээс дээш тохиромж муутай нөхцөлд үнэлэгдэж байна.

2.4. Уур амьсгалын онцлог

Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -38.30°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 36.90°C хүрдэг, үнэмлэхүй их бага температурын агууриг нь (75.20°C) эрс тэс ялгаатай. Жилийн дундаж температур нь 0.40°C , хамгийн хүйтэн I сарын дундаж температур -21.3°C бол 15 хамгийн дулаан сар болох VII сарын дундаж температур 19.50°C байдаг байна. Улаанбаатар хотод жилд дунджаар 257.1 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 173.1 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 89 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна. Салхины зонхлох чиглэлийн хувьд манай ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд баруунаас нийт салхины чиглэлийн 22.1% баруун хойноос, хойноос 20%, баруунаас 13.5% давтагдалтай байдаг. Салхины хурдны олон жилийн дундаж нь төдий л ихгүй ойролцоогоор 2.1 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул салхины хурд багасдаг байна. Хүйтэн өвөлтэй, сэрүүвтэр зунтай, эх газрын эрс тэс уур амьсгалтай бүс нутагт хамаарна. Жилд дунджаар 2800 цаг нартай байдаг бол 12-124 өдөр л наргүй өдөр тохиож байдаг байна. Агаарын жилийн дундаж температур $-1.5 - 3.1$ хэм, нэгдүгээр сарын дундаж хүйтэн -19 -өөс -22.4 хэм, долоодугаар сарын дундаж халуун нь $+12.4-17.6$ хэм хүрнэ. Уулын байрлал хотгор гүдгэрийн онцлог байрлалаас болоод газрын гадаргын орчмын салхины горим ихээхэн өөр өөр байдаг байна. Салхины жилийн дундаж хурд 0.9-2.3 м/сек, дундаж их хурд 5 сард 1.2-24.0 м/сек, хамгийн намуун үедээ 12-1 сард 0.7-1.24 м/сек дундажтай байна. Агаарын чийгшлийн горим нэлээд өвөрмөц, агаарын чийгшил нь халуун хүйтэндээ урвуу хамааралтай байдаг.

2.5. Усан орчин

Төслийн талбай нь гадаргын усны хувьд Туул голын сав газарт оршино. Туул гол нь Хан Хэнтий нурууны салбар уулс болох далайн түвшнээс дээш 2000м өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах Намьяа, Нэргүй хэмээх хоёр голын уулзвараас эх авна. Хэнтий нурууны салбар уулсаас эх авсан Галттай, Сарьдагийн Хийд, Хаг, Хонгор, Зүүн Баян, Тэрэлж, Хөлийн гол, Улиастай, Сэлбэ, Харбух зэрэг гол горхи Туулд цутгана.

Туул голын хөндий Улаанбаатар хотоос доош тавирч урсацын алдагдал ихэснэ. Туул голын жилийн дундаж өнгөрөлт Улаанбаатар орчим 26.6, Сонгинод 25.8, Өндөр ширээтэд 24.1 шоо м/с байна. Туул гол үерлэхдээ сав хөндийгөө дүүргэж, хуучин гольдрилдаа эргэн орж үндсэн гольдролоос алслан салаалах нь бий. Голын ус хурах талбай 48909.2 ам км, урт нь 898 км, хэвгий 0.0015 юм. Гольдролын дундаж өндөр 1160 м, ус хагалбарын шугамын урт 2055.6 км, түүний дундаж өндөр 1719.0 м, голуудын нийлбэр урт 11046.5 км, усан сүлжээний нягтшил 0.23 км/км², ус хурах талбайн дундаж өндөр 1300.0 м, хөндийн гүн дунджаар 559.0 м, түүний өргөн 54.4 км, сав газрын суналтын зэрэг 16.5, ус хагалбарын шугамын хөгжлийн зэрэг 2.6, хажуугийн хэрчигдэл 0.8 байна. Туул голын өргөн нь жирийн үед 35-75 м, гүн нь 0.8-3.5 м, урсгалын хурд 0.50-1.50 м/с болно.

Туул голын сав газрын хэмжээнд нүх сүвийн (бүрдэл), ан цавын (бүс) гэсэн үндсэн 2 төрлийн ус агуулагч бүрдэл тархсан ба ан цав-нүх сүвийн ус болох рашаан (Улаанбаатар, Ар, Өвөр Жанчивлан зэрэг нүүрс хүчилт хүйтэн рашаан) тархсан байна. Нүх сүвэрхэг бүрдэл нь доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдас дотор, ан цавлаг бүс нь кембри, девон, карбоны тунамал, хувирмал, эсвэл юра, триасын түрмэл чулуулаг дотор тус тус бүрэлддэг. Туул голын сав газрын хэмжээнд тархсан хурдас чулуулгийн нас, литологийн төрлийн нэлээд ерөнхийлөн нэгтгэж, тэдгээрийг нүх сүвшилт зонхилсон, эсвэл ан цавшилт зонхилсон байдлаар нь ангилж, газрын доорх усны судлагдсан түвшин, хөдөлгөөний төрхийг харгалзан уг сав газрын хэмжээнд ус агуулагч нүх сүвэрхэг 6 бүрдэл, ус агуулагч ан цавлаг 2 бүсийг ялгасан байна.

Улаанбаатар хотын төвлөрсөн усан хангамжийн усны нөөц нь Туул голын сав хөндий дагуух аллювийн хурдсанд агуулагдсан газрын доорх цэнгэг ус юм. Одоогийн байдлаар газар доорхи усны 4 эх үүсвэрээс тогтоогдсон нөөцийн дээд хэмжээ 248000 м³/хоног ус олборлож байна. Улаанбаатар хотын цэвэр бохир усны мастер төлөвлөгөөнд тусгаснаар усны хэрэглээ 2025 оны түвшинд 438000 м³/хоног болно гэж тооцжээ. ХАА-н усан хангамжийн зориулалтаар газрын доорх усны 800 м³/хоногоос-3.7 мян.м³/хоног нөөцтэй Бөхөг, Түргэн, Улиастай, Баянгол, Гацуурт, Хүй, Нарийн зэрэг голуудын ай савыг ашиглаж байна.

2.6. Хөрсөн бүрхэвч

Улаанбаатар хот нь хөрс газарзүйн мужлалаар уулын хар хүрэн хөрстэй Хэнтийн өмнөт тойрогт багтдаг. Хотын хөрс нь олон жилийн туршид хүний үйл ажиллагааны нөлөөгөөр элэгдэн эвдэрч, унаган хөрсгүй болсон онцлогтой. Улаанбаатар хотын суурин газрын нутаг дэвсгэрт ариун цэвэр-эрүүл ахуйн шаардлагыг хангах явдал чухал асуудлын нэг юм. Одоогийн байдлаар тухайн газрын ойр орчимд жижиг, дунд үйлдвэрүүд болон хүнд даацын тоног төхөөрөмжүүдийн агуулах байрласан болно. Ийм учраас техноген гаралтай бохирдол их байж болзошгүй юм.

Багаж хэрэгсэл: Хөрсний талбайн судалгаанд хүрз, метр, дээжний уут, 10%-ийн давсны хүчил, хөрсний өнгө тодорхойлох ном (Soil Munsell Chart), хөрсний суурь зураг, дээжний хутгуур, фото аппарат, GPS зэрэг багаж хэрэгслүүдийг ашигласан.

Хээрийн судалгаа: Хөрсний хээрийн буюу талбайн судалгааны явцад 1-н цэгээс шимт хөрсний буюу 0-30 см гүнээс дээжлэлт хийж 2 ширхэг дээж авсан. Дээжийг авахдаа “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990” стандартыг баримталсан. Дээж авсан цэгүүдийн ерөнхий мэдээллийг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 6. Хөрсний судалгаа хийгдсэн цэгийн ерөнхий мэдээлэл

№	Цэгийн дугаар	Ерөнхий байрлал	Хөрсний төлөв	Координат (D. degree)	
				X	Y
1	Дээж-1	Хүрэн өнгөтэй, хуурай, ургамлын үндэс элбэг, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, чулуужилтгүй.	Ердийн хүрэн хөрс	106 54 28	47 52 58
2	Дээж-2			106 54 27	47 52 58

Лабораторийн задлан шинжилгээ: Хээрийн судалгаагаар авсан хөрсний дээжүүдийг “Грийн лаб” ХХК -ийн хөрс судлалын лабораторид хуурай нөхцөлд хатааж 2 мм-ээр шигшиж лабораторийн задлан шинжилгээнд зориулан бэлдлээ. Лабораторид (рН, карбонат, ялзмаг, цахилгаан дамжуулах дамжуулах чанар, механик бүрэлдэхүүн, хөдөлгөөнт элементүүд-фосфор, кали, Хөрсөн дэх онцгой хортой (As, Cd, Cr, Pb) ба хортой био-идэвхт (Cu, Co, Mo, Ni, Sr, V, Zn) элементүүдийг) зэргийг тодорхойлуулсан.

Хүснэгт 7. Хөрсний дээжид задлан шинжилгээ хийсэн арга, нарийвчлал

Үзүүлэлт	Арга зүй	Стандарт
Дээж хатаах	Агаарын хуурай нөхцөлд	ISO 11464:2006: Soil quality - Pretreatment of samples for physico-chemical analysis
Дээж шигших	2 мм	
Урвалын орчин (рН)	Хөрс:ус (1:2.5), рН метр	Хөрсний чанар. рН-ыг тодорхойлох MNS ISO 10390-2001
Карбонат	Кальциметр, эзлэхүүний	Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга, MNS 3310:1991
Хялбар уусах давсжилт	Хөрс:ус (1:2.5), ЕС метр	
Ялзмаг	Тюрины, Бихроматын исэлдэлт	Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга, MNS 3310:1991
Хөдөлгөөнт Фосфор, Кали	Мачигины арга	Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга, MNS 3310:1991


Улаанбаатар хотын Хан-уул дүүрэг, Богдхан уулын дархан цаазат газрын Зайсангийн аманд хэрэгжих “Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Механик бүрэлдэхүүн	Пипеткийн арга	ISO11277:2009 Soil quality-Determination of particle size distribution in mineral soil material-Method by sieving and sedimentation
---------------------	----------------	---

Хөрсний зүсэлт, морфологи шинж чанар

Судалгааны явцад хийсэн зүсэлт, морфологи тогтоцын бичлэг, авсан дээжний лабораторийн задлан шинжилгээний дүнг үндэслэн тодорхойлолт өгөв.

Зураг 3. Төслийн талбай орчмын хөрсөн бүрхэвчийн хэв шинж



Хөрсний лабораторийн задлан шинжилгээ:

Хөрсний механик бүрэлдэхүүнийг Качинскийн буюу шимүүрийн аргаар тодорхойлоход физик шавар (<0.01мм)-ын хэмжээ хөрсний зүсэлт 1-т 21.9 % буюу хөнгөн шавранцар хөрс нэгж талбарт тархана.

Хөрсний урвалын орчин (pH) нь 5.6-6.0 бол дунд зэрэг хүчиллэг, 6.1-6.5 сул хүчиллэг, 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9.0 хүчтэй шүлтлэг гэжүздэг (“Soil survey manual. 1993. Chapter 3.”). Шинжилгээний дүнгээр талбайн хөрсний урвалынорчин (pH) 8.11-8.44 буюу шүлтлэг байна.

Хөрсөн дэх нийт хялбар уусах давсжилт буюу хөрсний цахилгаан дамжуулах чадвар (EC) нь 0.096-0.141 dS/m байгаа нь бага давсжилттай байна. (Хөрсний EC нь 1.2 dS/мээс дээш байгаа тохиолдолд бага давсжилттай, 8.64 dS/м-ээс дээш бол хэт их давсжилттай гэжүзнэ).

Хөрсний үржил шимийн үзүүлэлт болох хөдөлгөөнт фосфор 2.6-4.8 мг/100гбуюу хэвийн хангамжтай, кали 40-42 мг/100г буюу дундаж хангамжтай байна. Харин ялзмагийнбодис буюу органик бодисын агууламж элсэнцэр хүрэн хөрсөнд 1.55-2.37% байгаа нь ялзмагийн

агууламжаар дунд байна. Хүрэн хөрсний агууламж 2%-аас бага байдаг. Ялзмагийн бодис нь ойролцоогоор 60% нүүрстөрөгч, 6% азот болон фосфор, хүхэр зэрэг макро, микро элементүүдийг өөртөө агуулдаг байна. Олон улсын практикт хөрсний ялзмагийн агууламжаар нь маш бага буюу <1%, бага буюу 1- 2%, дунд зэрэг буюу 2-5%, их буюу >5% гэж хуваан авч үздэг.

Хүснэгт 8. Төслийн талбайн хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Дээжний нэр	гүн см	pH	Давс,%	ЦДЧ	CaCO3%	ялзмаг	Шингээгдсэн суурьд,мг-экв/100гр			Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
								Ca+Mg	Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
1	Дээж-1	0-20	7.82	0.04	0.080	0	5.67	33.8	32	1.8	1.3	15

Хүснэгт 9. Төслийн талбайн хөрсний механик бүрэлдхүүн

№	Дээжний нэр	Гүн,см	Механик ширхэгүүд,%ширхэгийн хэмжээ,мм						
			1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	Дээж-1	0-20	29.1	39.3	9.4	9.5	9.9	2.7	22.1

Төслийн талбайгаас хөрсний дээж авч “Green Lab” хөрс судлалын лабораторид шинжлүүлсэн. Уг шинжилгээний дүнгээс харахад төслийн талбайн хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж дунд зэрэг, солилцох калийн агууламж бага, хөдөлгөөнт фосфорын агууламж дунд зэргийн агууламжтай байна.

Манай оронд мөрдөгдөж буй [“Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” (MNS 5850: 2019)]-ын хүрээнд Монгол орны нутаг дэвсгэр дээрх хөрсөнд агуулагдаж болох бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх (хүлцэх) дээд хэмжээг тогтоох бөгөөд стандартад заагдсан хэмжээнээс давсан тохиолдолд тухайн хөрсийг бохидолд орсон гэж үзнэ. Энэ стандартад хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн хүлцэх (зөвшөөрөгдөх дээд хэмжээ) хэмжээ, хортой болон аюултай агууламжуудыг хөрсний бохирдол, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, тухайн газар нутгийн байгаль орчны мониторинг, хяналт, байгаль хамгаалал, хүн амын эрүүл ахуй, эрдэм шинжилгээ, сургалт, хөдөө аж ахуйн чиглэлээр хийгдэж байгаа хөрсний судалгааны ажлуудад мөрдлөг болгоно гэж заасан байдаг.

Хүснэгт 10. Төслийн талбайн хөрсний хүнд металл

№	Дээжний нэр	Гүн,см	Хүнд металл,мг/кг					
			Ni	Cd	Pb	Cu	Zn	Cr
1	Дээж-1	0-20	22.5	-	27.8	30.6	42.8	87.4
2	Дээж-2	0-20	31.1	-	13.6	10.7	49.6	22.5
Шавранцар хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ			100	1.5	70	80	150	100
Элсэнцэр хөрсний зөвшөөрөгдөх хэмжээ			60	1	50	60	100	60
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт			MNS 5850:2019					

2.7. Ургамлан нөмрөг

Төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Голоарктикийн их муж, Евразийн мужийн Төв Монголын хошууны Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамаарна. Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрог нь Хэнтийн нурууны захын салбар уулсыг хамрах бөгөөд Хэнтийн тойргийг тал цагираг байдлаар хүрээлэн оршино. Гадаргуугийн хувьд бэсрэг уул, толгод, ухаа гувээ ээлжлэн солигдоно. Тойргийн баруун хэсэгт Орхон Туулын


Улаанбаатар хотын Хан-уул дүүрэг, Богдхан уулын дархан цаазат газрын Зайсангийн аманд хэрэгжих “Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

бэлчир, Туулын тохой, Зэлтэр, Ерөө, Хараа, Шарын голуудын адаг, Ноён уул, Заамар, Жаргалантын нуруу; тойргийн зүүн хэсэгт Эрээн, Балж, Цэнхэрмандал, Биндэр орчмын бэсрэг уулс, Улз, Онон голууд энд хамаарна. Бэсрэг уулс д.т.д. 1400-1800 м хүрэх боловч зонхилох өндөр нь дунджаар д.т.д. 800- 1500 м, хөндийнүүд нь д.т.д. 1100-1200 м-т, Шаамар хавьд д.т.д. 800-1000 м-т оршино (Өлзийхутаг, 1989).

Богдхан ууланд 70 овогт хамаарах 256 төрлийн 588 зүйл дээд ургамалтай. Эдгээрийн 571 зүйл ургамал далд үртэн юм. Улалж, арилж, ортууз зэрэг 11 томоохон төрөлд хамаарах 135 зүйл ургамал нийт зүйлийн бүрэлдэхүүний 22.9 хувийг эзэлнэ. Ургамлын аймаг нь экологийн 18 бүлэгт хамаарах бөгөөд эдгээрээс уулын тайгын экологийн бүлгүүд 80 хувийг, ойт хээрийн ургамалжил 72 хувийг тус тус эзэлдэг. Амьдралын хэлбэрийн хувьд 87 хувийг өвслөг ургамал, 12 хувийг модлог ургамал эзэлнэ. Цармийн, ойн, хээрийн болон нугын хэв шинжид хамаарах ургамлан нөмрөгтэй бөгөөд дархан цаазат газрын 55 хувь нь ойтой. Уулын оройн хярын 2100 /2150/ метрээс дээш өндөрт орших хэсэг асга, хадны завсар зайгаар бушилз-улалж, боролж зонхилсон цармын бүслүүр илэрнэ.

Төслийн талбай нь Нуга, намгархаг нуга Уулын ой хэв шинжтэй бөгөөд ургамлын бүлгэмдлээр Хиаг-улалжит-70, үетэн-алаг өвст-20, бударгана-алаг өвстэй дэрс-10, бургасулиасан төгөл-10, бүхий нуга, Хялгана-зүр өвс-алаг өвст (20%) ба ботууль-алаг өвстэй (10%) шинэсэн болон шинэс-хусан ойн алаг өвс-үетэнт бүлгэмдэл зонхилсон байна.

Зураг 4. Төслийн талбай орчмын ургамлан бүрхвчийн байдал



2.8. Амьтны аймаг

Улаанбаатар хот орчмын ой, ойт хээрийн бүсэд нийт 6 багт багтах 51 зүйлийн хөхтөн амьтныг судлаачид бүртгээд байсан боловч сүүлийн үед эдгээрийн зарим зүйл нь хотжилт, суурьшлын нөлөөгөөр дайжин алга болжээ. Амьтны аймгийн хувьд Хан-уул дүүрэг, Зайсангийн ам нутаг нь амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь

бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Тухайлбал шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (*P.domesticus*) ба хээрийн (*P.montanus*) бор шувуу, хөхвөр тагтаа (*C.livia*), Сохор элээ (*Milvus migrans*), Шаазгай (*Pica pica*), Улаан хошуут (*Pyrrhocorax pyrrhocorax*), Хар хэрээ (*Corvus corone*), Хон хэрээ (*Corvus corax*) арай олон үзэгдэнэ. Хөхтний дотроос гэрийн хулгана нутагшиж байна. Шавжийн ангиас ихэвчлэн төрөл бүрийн цохын овог тааралдана.

2.9. Нийгэм эдийн засгийн төлөв байдал

Хан-Уул дүүрэг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын баруун урд хэсэгт дархан цаазат Богд хан Уулын ар хормой, Хатан Туулын хөвөөнд 48500га нутаг дэвсгэрийг хамран оршино. Тус дүүрэгт 64071 өрхийн 239035 иргэн, 23,584 аж ахуйн нэгж, үйлдвэр, компани, нөхөрлөл, хоршоотой, 42,867 толгой малтай, 482.860 тахиа, 3.610 гахай бүхий эрчимжсэн аж ахуйтай, хүлэмжийн аж ахуй, агро парк бүхий газар тариалан хөгжсөн бүс нутаг юм.

Хан-Уул дүүрэг нь Монгол Улсын Аж үйлдвэрийн тулгын чулууг тавьсан Ажилчны райоонаас үүсэлтэй ба одоогоор тус дүүрэгт “Говь” ХК, “Гоёо” ХХК, “Кашмер Холдинг” ХХК, “МАК” корпораци, “АПУ” ХК, “Витафит” групп, “Таван богд” ХХК, “Атар өргөө” ХК, “Монфрэш” ХХК, “Жем интернейшнл” ХХК, Дулааны 3 дугаар цахилгаан станц ТӨҮГ, МИАТ ХК, “Зорчигч Тээврийн нэгтгэл” ОНӨҮГ, “Биокомбинат” ОНӨҮГ зэрэг үндэсний томоохон компаниуд үйл ажиллагаа явуулж байна. Тус дүүрэгт үндэсний томоохон компани үйлдвэрлэлээс гадна тахиа, гахайны эрчимжсэн аж ахуй, хүлэмжийн аж ахуй, агро парк бүхий газар тариалан хөгжсөн бүс юм. Мөн Нийслэл хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын томоохон ажлууд болон шинэ сургууль, цэцэрлэг, худалдаа, соёл үйлчилгээ, өндөр зэрэглэлийн орон сууцнууд барих зэргээр дүүргийн өнгө төрх, ая тохитой ажиллаж амьдрах орчин өдрөөс өдөрт дээшилж байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлэхдээ өмнөх шатанд тодорхойлогдсон болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд, түүний үйлчлэлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нутгийн оршин суугчид, түүх, соёлын өвд бий болох сөрөг үр дагавар, түүний эрчим, цар хүрээ, шууд болон шууд бус нөлөөллүүд, болзошгүй нөлөөллийг Монгол улсын хууль тогтоомжид заасан болон олон улсын нийтлэг аргуудыг ашиглан үнэлж, тайланд тусгав.

3.1. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экосистемийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг. Төслийн байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн үнэлгээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 11. Төслийн болзошгүй нөлөөллийн магадлан жагсаах аргаар үнэлсэн үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөлөл байхгүй	Нөлөөллийн эрчим		
			Бага	Дунд	Их
1. Төслийн байршилтай холбогдон гарах нөлөөлөл					
1	Хүн ам нүүлгэн шилжүүлэх асуудал	0			
2	Тусгай хамгаалалттай бүс нутгийн ховор, ховордсон биологийн төрөл зүйлийн амьдрах орчин		-		
3	Түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдворт газрыг эвдэхэд хүргэх	0			
4	Ой модыг огтлох, гэмтээх асуудал	0			
5	Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх		-		
6	Булаг шандын усны горимд өөрчлөлт орох ба хатаж ширгэх аюултай эсэх		-		
7	Голын голдирол эвдэж өөрчлөх эсэх	0			
8	Байгалийн эрдэс баялгийг ашиглах эсэх	0			
2. Төслийн шийдэлтэй холбогдол бүхий нөлөөлөл					
9	Үйл ажиллагаа нь тухайн орон нутагт нийцтэй эсэх			+	
10	Төслийн үйл ажиллагаанд тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, бодис хэрэглэх эсэх		-		
11	Төслийн үйл ажиллагаанд сонгосон техник, тоног төхөөрөмжийн шийдэл, түүхий эд нь байгаль орчинд хэр нийцтэй эсэх			+	
3. Барилга байгуулалтын үеийн нөлөөлөл					
12	Барилга байгууламж барих үед усны нөөц бохирдох эсэх		-		
13	Барилга байгууламж барих үеийн болон барьсны дараах хөрсний эвдрэл			-	
14	Барилга байгууламж барих үед осол аваар, хортой нөхцөл үүсэх эсэх		-		
4. Төслийн үйл ажиллагааны холбогдол бүхий нөлөөлөл					
15	Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх			+	
16	Хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулах орчныг тохижуулах төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан эсэх				+

Улаанбаатар хотын Хан-уул дүүрэг, Богдхан уулын дархан цаазат газрын Зайсангийн аманд хэрэгжих “Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

17	Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс, ургамал талхлагдах эсэх			-	
